



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/121

Хужирт сум

Төв суурингийн 2021-2022 оны
өвөлжилтийн бэлтгэл хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “а”дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 221 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2021 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай” А/376 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу сайтар зохион байгуулж, биелэлтийн үр дүнг 2021 оны 10 дугаар сарын 10-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Б.Дэмбэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2020 оны
09 дугаар сарын 13-ны өдрийн 44 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ,
ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Дэмбэрэл - Засаг даргын Орлогч
Нарийн бичгийн дарга: С.Самдан - Мал аж ахуйн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд: Д.Уранчимэг – Санхүүгийн албаны дарга
Д.Мөнхбат- Бэлчээр, газар тариалангийн асуудал
хариуцсан мэргэжилтэн
Д.Батбаяр 4 дүгээр багийн Засаг дарга
Ц.Лхамролом 5 дугаар багийн Засаг дарга
Э.Оюунпүрэв Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
А.Гантулга ЕБСургуулийн захирал
З.Оюунчимэг 1 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч
Ш.Эрдэнэхорол 2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч
Д.Норов 3 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч
С.Батцэцэг 4 дүгээр Цэцэрлэгийн эрхлэгч
О.Долгормаа Соёлын төвийн эрхлэгч
Ц.Тунгалаг Цаг уур өртөөний эрхлэгч
Ч.Нэргүй “Хужирт илч” ХХК-ний захирал
Ц.Туул “Шунхлай Ач” ХХК-ний захирал
О.Базарсад “Монгол засвар” ХХК-ний захирал

Сумын Засаг даргын 2021 оны
09-р сарын 13-ны өдрийн 44-р
захирамжийн 2-р хавсралт

ХУЖИРТ СУМЫН 2021-2022 ОНЫ ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН
БЭЛТГЭЛ ХАНГАХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ

Хийх ажил	Хугацаа	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага.
Нэг :Удирдлага зохион байгуулалтын талаар		
1. Хөдөө аж ахуйн 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажиллах	9 дүгээр сарын 01-ны дотор	ХАА-н тасгийн мэргэжилтэн С.Самдан
2. Хөдөө аж ахуйн болон мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, шалгах хүлээн авах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх	10 дугаар сарын 10-ны дотор	Засаг даргын орлогч Б.Дэмбэрэл
3. Сумын өвс, тэжээлийн аюулгүй нөөц, малчдын түвшинд бэлтгэх өвс, гар тэжээл, хужир шүүг бэлтгэх тоо хэмжээнд хяналт тавьж аж ахуйн нэгж иргэдийн тариалсан ногоон тэжээлээр орон нутагтаа нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах	9,10-р саруудад	Сумын ЗДТГ, ХААТ, БЗДарга нар
4. Малчдын хувийн бэлтгэлийг хангахад анхаарч цаг агаарын мэдээ, мэдээлэлийг утас болон цахим хуудас, мессеж модем ашиглан тухай бүрд авч байх боломжийг бүрдүүлэх, цаг хүндэрсэн үед өргөн хэрэглээний бараа, төрийн болон хүн эмнэлгийн үйлчилгээгээр хангах ажлыг зохион байгуулах	Тухай бүрд	Ажлын хэсэг
5. Сумын ажлын хэсэг өвөлжилтийн бэлтгэл хангалтын байдалтай газар дээр нь танилцаж айл өрх бүртэй танилцаж үнэлгээ дүгнэлт өгөх	Тухай бүрд	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Хоёр: Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах талаар		
2.1 Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангах талаар		
1. 2021 оны 08 дугаар сарын 20-аас эхлэн хадлан тэжээл бэлтгэх бололцоотой аж ахуй нэгж, иргэд, малчдын хүчийг хадлан тэжээл бэлтгэх ажилд чиглүүлэх малчдын түвшинд бэлтгэсэн өвс, тэжээлийн нөөцийн мэдээг малчин өрхийн нэрээр нарийвчлан гаргах	10-р сарын 15-ны дотор	БЗДарга нар, ХАА-н тасаг
2. Шинээр гаргаж буй инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргаж буй аж ахуй нэгжийн		